



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/125

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7, 48.2.9 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны хатуу эдлэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ш.Базарханд (Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сургалтын менежер)

Гишүүд: Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Ц.Нандин-Эрдэнэ (Дотуур байрын багш)


Б.Болормаа (Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн багш)

Г.Тунгалаг (Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн нярав)

2.Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсэг (Ш.Базарханд)-д даалгасугай.

3.Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас санхүүжүүлсэн Ерөнхий боловсролын сургуулийн Дотуур байрны хатуу эдлэлийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Б.Сангицэрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



САМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

022308265